



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

2025 оны 7 дугаар сар

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025 оны 08 сарын 20
Улаанбаатар хот

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт

Тодорхойлолт*

Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

ТАНИЛЦСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.БАТБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ц.НЭМЭХЖАРГАЛ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. АЧАА ТЭЭВЭР	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР	7
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР	8
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА	8
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	12
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР	10
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА	10
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ	13
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР	14
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА	14
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	20
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ	16
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ	17
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ	18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....	8
Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....	10
Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....	13
Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....	14
Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....	15
Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	16
Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	17
Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	7
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....	8
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 9. Автотээврийн зорчигч.....	9
Зураг 10.Төмөр замын ачаа	10
Зураг 11. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	11
Зураг 12. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	11
Зураг 13. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	11
Зураг 14. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	11
Зураг 15. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.07.31.....	12
Зураг 16. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	12
Зураг 17. Төмөр замын зорчигч тээвэр.....	13
Зураг 18. Төмөр замын зорчигч, хоногоор.....	13
Зураг 19. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	14
Зураг 20. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	14
Зураг 21. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	14
Зураг 22. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	15
Зураг 23. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	15
Зураг 24. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	16
Зураг 25. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	17
Зураг 26. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	17
Зураг 27. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	18
Зураг 28. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	18

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ²

Хүснэгт 1



№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
				7-р сар	Өссөн дүн	7-р сар	Өссөн дүн	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	7,485.6	50,749.5	6,685.1	48,176.6	-5.1%
		Төмөр зам	мян.тн	3,707.5	25,461.1	3,853.7	24,741.4	-2.8%
		Агаар	мян.тн	0.9	5.5	0.7	5.3	-3.4%
		Нийт ачаа	мян.тн	11,194.0	76,216.1	10,539.6	72,923.4	-4.3%
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	487.2	3,128.5	514.0	3,424.4	9.5%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	1,032.4	6,498.3	1,017.4	6,514.5	0.2%
		Автотээвэр	мян.тн	7,159.3	49,035.6	6,438.6	46,395.8	-5.4%
		Нийт	мян.тн	8,191.7	55,533.9	7,456.0	52,910.3	-4.7%
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	333.2	2,212.8	331.5	2,086.7	-5.7%
		Автотээвэр	мян.тн	326.3	1,713.8	246.5	1,780.6	3.9%
		Нийт	мян.тн	659.5	3,926.6	578.0	3,867.3	-1.5%
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,854.7	13,621.5	1,990.8	12,715.8	-6.6%
		Агаар	мян.тн	0.9	5.5	0.7	5.3	-3.4%
		Нийт	мян.тн	1,855.6	13,627.1	1,991.5	12,721.1	-6.6%
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	1,102.6	7,584.7	971.9	7,013.2	-7.5%
		Төмөр зам	сая тн.км	1,779.6	12,172.1	1,937.9	12,498.4	2.7%
		Агаар	сая.тн.км	2.3	16.5	2.1	14.0	-15.1%
		Нийт	сая тн.км	2,884.5	19,773.2	2,911.9	19,525.6	-1.3%
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	9,501.2	82,611.8	8,814.6	84,028.2	1.7%
		Төмөр зам	мян.хүн	205.3	1,177.2	167.8	1,030.5	-12.5%
		Агаар	мян.хүн	270.4	1,200.4	293.5	1,356.7	13.0%
		Нийт зорчигч	мян.хүн	9,977.0	84,989.3	9,275.8	86,415.5	1.7%
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	83.8	446.5	49.2	343.0	-23.2%
		Төмөр зам	мян.хүн	7.1	28.8	5.1	26.7	-7.3%
		Агаар	мян.хүн	230.2	957.1	250.0	1,106.0	15.6%
		Нийт	мян.хүн	321.2	1,432.4	304.3	1,475.7	3.0%
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	158.7	907.8	162.2	962.6	6.0%
		Төмөр зам	мян.хүн	198.2	1,154.9	162.7	1,003.8	-13.1%
		Агаар	мян.хүн	40.2	243.3	43.4	250.7	3.0%
		Нийт	мян.хүн	397.1	2,306.0	368.3	2,217.2	-3.9%
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	9,258.7	81,257.5	8,603.2	82,722.6	1.8%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	182.1	1,268.4	178.8	1,307.9	3.1%
		Төмөр зам	сая хүн.км	78.4	459.2	66.3	424.6	-7.5%
		Агаар	сая хүн.км	603.1	2,726.4	651.8	2,996.1	9.9%
		Нийт	сая хүн.км	863.6	4,454.0	896.9	4,728.5	6.2%
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	1,563.0	7,187.0	1,841	8,153	13.4%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	1,373.0	5,971.0	1,931	6,944	16.3%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	6,052.0	36,740.0	7,036	44,645	21.5%

² Зам, тээврийн салбарын 2025 оны 7 дугаар сарын статистикийн мэдээг 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2025 оны 7 дугаар сард 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 5.8%-аар буурсан байна. Харин 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 7 сард нийт 72.9 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3%-аар буурсан байна.


- 2025 оны 7 дугаар сард автотээврээр 6.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 10.7%-аар буурсан байна. Өссөн дүнгээр автотээврээр нийт 48.2 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1%-аар, экспортын ачаа 46.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 5.4%-аар тус тус буурсан бол импортын ачаа 1.8 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 3.9%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр Төмөр замын тээврээр 2025 оны 7 дугаар сард нийт 3.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 3.9%-аар өсжээ. Өссөн дүнгээр нийт 24.7 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8%-аар буурсан. Үүнээс дотоодын ачаа 12.7 сая тонн болж 6.6%-аар, импортын ачаа 2.1 сая тонн болж 5.7%-аар тус тус буурсан бол экспортын ачаа 6.5 сая тонн 0.2%-аар, дамжин өнгөрсөн ачаа 3.4 сая тонн болж 9.5%-аар тус тус өссөн байна.
- Агаарын тээврээр 2025 оны 7 дугаар сард 714.5 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 22.8%-аар өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 5,315.9 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 3.5%-аар буурсан бол орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 22.6 тонн болж өмнөх оны мөн үеэс 76.1%-аар өссөн байна.



Экспортоор 7 дугаар сард 7.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 9%-аар буурсан байна. 2025 оны өссөн дүнгээр экспортын хэмжээ 52.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 4.7%-аар буурсан байна. Үүнээс төмөр замаар 6.5 сая тонн тээвэрлэсэн нь 0.2%-аар буурсан бол автотээврээр 46.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.4%-аар буурсан байна. Нийт экспортын дүнд автотээвэр 88%-ийг, төмөр зам 12%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2025 оны 7 дугаар сард нийт 578 мянган тонн болж өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 12.4%-аар буурсан. Харин нийт өссөн дүнгээр 3.9 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс 1.5%-аар буурчээ. Үүнээс төмөр замаар 2.1 сая тонн ачаа импортолсон нь 5.7%-аар буурсан бол автотээврээр 1.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9%-аар өссөн байна. Импортын тээврийн 54%-ийг төмөр замаар, 46%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/

Зураг 3. Нийт импорт




1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Бүх төрлийн тээврээр 2025 оны 7 дугаар сард 9.3 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 7%-аар буурсан. 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 7 сард 86.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2025 оны 7 дугаар сард 8.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 7 дугаар сараас 7.2%-аар буурсан байна. Өссөн дүнгээр нийт 84 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 82.7 сая зорчигч (+1.8%), орон нутагт 962.6 мянган зорчигч (+6.0%), олон улсад 343 мянган зорчигч (-23.2%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замаар 2025 оны 7 дугаар сард нийт 167.8 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 18.3%-аар буурсан. Нийт өссөн дүнгээр 1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.5%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 26.7 мянган зорчигч зорчсон нь 7.3%-аар, орон нутагт 1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.1%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2025 оны 7 дугаар сард нийт 293.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 8.5%-аар өссөн. Өссөн дүнгээр нийт 1.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.0%-аар өссөн бол үүнээс олон улсад 1.1 сая зорчигч зорчсон нь 15.6%-аар, орон нутагт 250.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.0%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсын зорчигч



2025 оны эхний 7 сард олон улсад нийт 1.5 сая зорчигч (+3.0%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 1.1 сая зорчигч (+15.6%), автотээврээр 343 мянган зорчигч (-23.2%), төмөр замаар 26.7 мянган зорчигч (-7.3%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 75%, автотээвэр 23%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2025 оны эхний 7 сард орон нутагт нийт 2.2 сая зорчигч (-3.9%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 962.6 мянган зорчигч (+6.0%), төмөр замаар 1 сая зорчигч (13.1%), агаарын тээврээр 250.7 мянган зорчигч (+3.0%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутагт зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА³

2025 оны өссөн дүнгээр авто замаар нийт 48.2 сая тонн ачаа тээвэрлэснээс 46.4 сая тонн ачаа экспортолсон байна.


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 2 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт ачаа	мян.тн	7,485.6	50,749.5	6,685.1	48,176.6	-5.1%
Импорт	мян.тн	326.3	1,713.8	246.5	1,780.6	3.9%
Экспорт	мян.тн	7,159.3	49,035.6	6,438.6	46,395.8	-5.4%
Ачаа эргэлт	сая тн.км	1,102.6	7,584.7	971.9	7,013.2	-7.5%

2025 оны 7 дугаар сард автотээврээр 6.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 10.7%-аар буурсан байна. Үүнээс экспортод 6.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 10.1%-аар, импортоор 246.5 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сараас 24.4%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 7 дугаар сард 971.9 тэрбум тонн км болсон нь өмнөх оны 7 дугаар сараас 11.9%-аар буурсан байна.

Эхний 7 сарын байдлаар автотээврээр нийт 48.2 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1%-аар, экспортын ачаа 46.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 5.4%-аар тус тус буурсан бол импортын ачаа 1.8 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 3.9%-аар өссөн байна. Ачаа эргэлт 7.0 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 7.5%-аар буурсан байна.

2025 оны өссөн дүнгээр автотээврийн нийт ачаа тээврийн 46.4 сая тонн буюу 96%-ийг экспортын ачаа, 1.8 сая тонн буюу 4%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлсээр байна. /Зураг 8/

Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь




2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Хүснэгт 3 Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч	хүн	9,501.2	82,611.8	8,814.6	84,028.2	1.7%
Олон улсад	хүн	83.8	446.5	49.2	343.0	-23.2%
Хот хоорондын	хүн	158.7	907.8	162.2	962.6	6.0%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	хүн	9,258.7	81,257.5	8,603.2	82,722.6	1.8%
Зорчигч эргэлт	сая хүн.км	182.1	1,268.4	178.8	1,307.9	3.1%

³ "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын статистикийн мэдээ

Зураг 9. Зорчигч тээвэр



Автотээврээр 2025 оны 7 дугаар сард 8.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 7 дугаар сараас 7.2%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 49.2 мянган зорчигч (-41.3%), орон нутагт 162.2 мянган зорчигч (+2.2%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 8.6 сая зорчигч (-7.1%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 84 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 82.7 сая зорчигч (+1.8%), орон нутагт 962.6 мянган зорчигч (+6.0%), олон улсад 343 мянган зорчигч (-23.2%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.7%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.0%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 9/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээврээр 2025 оны өссөн дүнгээр нийт 24.7 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8%-аар буурлаа.


Хүснэгт 4

Үзүүлэлт	Хэмжиг нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын %/өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Ачаа тээвэрлэлт	мян.тн	3,707.5	25,461.1	3,853.7	24,741.4	-2.8%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,610.2	19,009.0	2,687.1	18,636.9	-2.0%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	279.2	1,500.0	617.3	2,180.8	45.4%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	349.3	2,213.7	0.0	695.7	-68.6%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	290.0	1,971.7	341.9	2,279.0	15.6%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	178.7	766.6	207.4	948.9	23.8%
Дотоодын ачаа	мян.тн	1,854.7	13,621.5	1,990.8	12,715.8	-6.6%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	757.4	7,169.4	824.2	6,611.3	-7.8%
үүнээс "Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	279.2	1,500.0	617.3	2,180.8	45.4%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	349.3	2,213.7	0.0	695.7	-68.6%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	290.0	1,971.7	341.9	2,279.0	15.6%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	178.7	766.6	207.4	948.9	23.8%
Импорт ачаа	мян.тн	333.2	2,212.8	331.5	2,086.7	-5.7%
БНХАУ-аас	мян.тн	64.8	543.4	81.9	529.5	-2.6%
ОХУ-руу	мян.тн	268.4	1,669.4	249.6	1,557.2	-6.7%
Экспорт ачаа	мян.тн	1,032.4	6,498.3	1,017.4	6,514.5	0.2%
БНХАУ-руу	мян.тн	1,013.7	6,387.5	1,002.8	6,417.8	0.5%
ОХУ-руу	мян.тн	18.7	110.8	14.6	96.6	-12.8%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	487.2	3,128.5	514.0	3,424.4	9.5%
БНХАУ-аас ОХУ-руу	мян.тн	157.1	962.5	165.0	1,025.4	6.5%
ОХУ-аас БНХАУ-руу	мян.тн	330.1	2,166.0	349.0	2,399.0	10.8%
Ачаа эргэлт	сая.тн-км	1,779.6	12,172.1	1,937.9	12,498.4	2.7%

Төмөр замын тээврээр 2025 оны 7 дугаар сард нийт 2.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 3.9%-аар өсжээ. Үүнээс дотоодын ачаа 2 сая тонн болж өмнөх оны 7 дугаар сараас 7.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 514 мянган тонн болж 5.5%-аар тус тус өссөн бол экспортын ачаа 1 сая тонн болж 1.5%-аар, импортын ачаа 331.5 мянган тонн болж 0.5%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 4/

2025 оны өссөн дүнгээр нийт 24.7 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8%-аар буурсан. Үүнээс дотоодын ачаа 12.7 сая тонн болж 6.6%-аар, импортын ачаа 2.1 сая тонн болж 5.7%-аар тус тус буурсан бол экспортын ачаа 6.5 сая тонн 0.2%-аар, дамжин өнгөрсөн ачаа 3.4 сая тонн болж 9.5%-аар тус тус өссөн байна. /Зураг 10/

Зураг 10. Төмөр замын ачаа, мян.тн




Зураг 11. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Эхний 7 сарын байдлаарх нийт ачаа тээврийн 18.6 сая тонн буюу 75%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 2.3 сая тонн буюу 9%-ийн ачааг "Монголиантранс Логистик" ХХК, 2.2 сая тонн буюу 9%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 695.7 мянган тонн буюу 3%-ийн ачааг "Тавантолгой төмөр зам" ХХК, 948.9 мянган тонн ачаа буюу нийт ачааны 4%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 11/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 12.7 сая тонн буюу 51%-ийг дотоодын ачаа, 6.5 сая тонн буюу 26%-ийг экспортын ачаа, 3.4 сая тонн буюу 14%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 2.1 сая тонн буюу 9%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 12/

Зураг 12. Төмөр замын ачаа тээврийн төрөл




Зураг 13. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Дотоодод тээвэрлэсэн 12.7 сая тонн ачааны 6.6 сая тонн ачаа буюу 52%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 2.3 сая тонн ачаа буюу 18%-ийг "Монголиантранс Логистик" ХХК, 2.2 сая тонн буюу 17%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 695.7 мянган тонн ачаа буюу 6%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 948.9 мянган тонн буюу 7%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 13/

2025 оны 7 дугаар сарын байдлаар байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 86.7 мянган тонн, "МТЛогистик" ХХК нь 11.0 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 19.9 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 6.7 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 14/

Зураг 14. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар




Зураг 15. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.07.31



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуус оруулав. 2025 оны 7 дугаар сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 59.1 мянга, экспортын ачаа 32.2 мянга, дамжин өнгөрсөн ачаа 16.2 мянга, импортод дундажаар 4.5 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 15/

Зураг 16 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



2025 оны эхний 4 сар буюу 2025.01.01-ний өдрөөс 2025.07.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 16/


3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Төмөр замаар 2025 оны эхний 7 сард 15.1 мянган зорчигч олон улсад тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.4%-аар өссөн байна.

Хүснэгт 5

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	205.32	1,177.2	167.8	1,030.5	-12.5%
Олон улс	мян.хүн	7.08	28.8	5.1	26.7	-7.3%
Орон нутаг	мян.хүн	198.2	1,154.9	162.7	1,003.8	-13.1%
Зорчигч эргэлт	сая хүн.км	78.41	459.2	66.3	424.6	-7.5%


2025 оны 7 дугаар сард нийт 167.8 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 18.3%-аар буурсан. Үүнээс олон улсад 5.1 мянган зорчигч зорчсон нь 28.5%-аар, орон нутагт 162.7 мянган зорчигч зорчсон нь 17.9%-аар буурчээ.



Өссөн дүнгээр нийт 1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.5%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 26.7 мянган зорчигч зорчсон нь 7.3%-аар, орон нутагт 1 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.1%-аар тус тус буурсан байна. Зорчигч эргэлт 424.6 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 7.5%-аар буурчээ.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь төмөр замын зорчигч тээврийн 98%-ийг эзэлж буй орон нутагт зорчих зорчигчдын тоо тогтмол буурч байгаатай холбоотой бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна. /Зураг 17/

Зураг 18. Төмөр замын зорчигч, хоногоор



2025.01.01-2025.07.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос нэгтгэн гаргав. 2025 оны эхний 7 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.5 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 18/


БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
			7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	925.5	5,524.0	714.5	5,338.4	-3.4%
2	олон улсад	тн	922.7	5,511.1	712.9	5,315.9	-3.5%
3	орон нутагт	тн	2.8	12.9	1.6	22.6	76.1%
4	Нийт ачаа	тн	912.0	5,398.1	703.0	5,230.3	-3.1%
5	олон улсад	тн	909.2	5,385.4	701.4	5,207.9	-3.3%
6	орон нутагт	тн	2.8	12.8	1.6	22.4	75.3%
7	Нийт шуудан	тн	13.5	125.8	11.5	108.1	-14.1%
8	олон улсад	тн	13.5	125.7	11.5	107.9	-14.1%
9	орон нутагт	тн	0.0	0.1	0.0	0.3	188.9%
10	Ачаа, шуудан эргэлт	мян.тн-км	2,278.5	16,470.4	2,145.26	13,993.0	-15.0%
11	олон улсад	мян.тн-км	2,276.9	16,463.3	2,144.40	13,979.1	-15.1%
12	орон нутагт	мян.тн-км	1.6	7.1	0.9	13.9	95.1%

Зураг 19. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан



Агаарын тээвэрээр 2025 оны 7 дугаар сард 714.5 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 22.8%-аар буурсан. Үүнээс ачаа 703 тонн болж 22.9%-аар, шуудан 11.5 тонн болж 14.7%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Харин өссөн дүнгээр 5,338.4 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 3.4%-аар буурсан байна. Үүнээс ачаа 5,230.3 тонн тээвэрлэсэн нь 3.1%-аар, шуудан 108.1 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.1%-аар тус тус буурсан байна. /Зураг 19/

2025 оны өссөн дүнгээр олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 5,315.9 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 3.5%-аар буурсан бол орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 22.6 тонн болж өмнөх оны мөн үеэс 76.1%-аар өссөн байна. /Зураг 20/


Агаарын тээвэрээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.6%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.4%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.9%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.1%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2025 оны өссөн дүнгээр 13.9 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 15%-аар бууржээ.

Зураг 20. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан



Зураг 21. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2025 оны эхний 7 сард нийт 1.4 сая зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 13.0%-аар өслөө.

						Хүснэгт 7
Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт зорчигч тээвэр	хүн	270,449	1,200,380	293,464	1,356,709	13.0%
Олон улсад	хүн	230,244	957,051	250,023	1,105,963	15.6%
Орон нутагт	хүн	40,205	243,329	43,441	250,746	3.0%
Зорчигч эргэлт	мян.хүн км	603,063.0	2,726,438.9	651,755.0	3,141,170.0	15.2%
Олон улсад	мян.хүн км	577,043.0	2,576,251.4	624,388.0	2,996,131.0	16.3%
Орон нутагт	мян.хүн км	26,020.0	150,187.5	27,367.0	145,039.0	-3.4%

Зураг 22. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо




2025 оны 7 дугаар сард агаарын тээврээр нийт 293.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 8.5%-аар өссөн. Үүнээс олон улсад 250 мянган зорчигч зорчиж 8.6%-аар, орон нутагт 43.4 мянган зорчигч зорчиж өмнөх оны 7 дугаар сараас 8%-аар тус тус өссөн байна.

Өссөн дүнгээр нийт 1.4 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.0%-аар өссөн бол үүнээс олон улсад 1.1 сая зорчигч зорчсон нь 15.6%-аар, орон нутагт 250.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 3.0%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 7/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна. /Зураг 22/

Зураг 23. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




Зорчигч эргэлт 2025 оны өссөн дүнгээр 3,141.2 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2%-аар өссөн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 2,996.1 сая хүн км болж 16.3%-аар өссөн бол орон нутгийн зорчигч эргэлт 145 сая хүн км болж 3.4%-аар буурсан байна.

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Олон улсад	230,244	957,051	250,023	1,105,963	15.6%
2	чиглэл Сөүл	94,960	349,597	87,900	356,570	2.0%
3	Бээжин	30,740	146,889	35,233	176,918	20.4%
4	Токио	16,030	69,417	19,770	89,423	28.8%
5	Истанбул	16,304	83,364	16,702	80,927	-2.9%
6	ХонКонг	12,418	52,723	13,040	63,804	21.0%
7	Франкфурт	12,685	44,436	14,982	52,890	19.0%
8	Бусан	11,814	38,841	12,815	44,879	15.5%
9	Хөх хот	5,116	26,304	5,352	31,239	18.8%
10	Чонжү	3,517	6,758	7,944	20,493	203.2%
11	Фукуок	0	18,071	31	19,057	5.5%
12	Санья/Хайнань	1,408	8,425	2,554	18,577	120.5%
13	Алмата	2,126	11,327	3,137	15,789	39.4%
14	Бангкок	0	10,927		13,558	24.1%
15	Тэгү	3,786	5,115	4,934	13,517	164.3%
16	Хо Ши Мин	0	2,101		11,068	426.8%
17	Эрхүү	2,411	10,333	1,778	10,152	-1.8%
18	Ордос	0	0	2,314	9,836	-
19	Пукет	0	7,900		9,405	19.1%
20	Муан	4,093	9,937	3,989	8,360	-15.9%
21	Хайкоу/Хайнань	0	4,485	877	7,102	58.4%
22	Бусад чиглэлд	12,836	51,917	16,671	51,561	-0.7%


Зураг 24. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



2025 оны эхний 7 сарын байдлаар олон улсад нийт 1.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 15.6%-аар өссөн. Хамгийн их зорчигч зорчсон Сөүл чиглэлд 356.6 мянган зорчигч (+2.0%), Бээжин хотруу 176.9 мянган зорчигч (+20.4%), Токио чиглэлд 89.4 мянган зорчигч (+28.8%), Истанбул чиглэлд 80.9 мянган зорчигч (-2.9%), ХонгКонг чиглэлрүү 63.8 мянган зорчигч (+21%), Франкфурт чиглэлд 52.9 мянган зорчигч (+19%) тус тус тээвэрлэсэн байна. Харин Чонжү, Хо Ши Мин, Хайнань чиглэлд зорчигчийн тоо эрс нэмэгдсэн нь гадагшаа чиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой байна. Дээрх графикт хамгийн их зорчигч зорчсон 20 хотуудыг харуулав. /Зураг 24/

Олон улсад зорчсон зорчигчдын 46% буюу 508.9 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Айрчайна”-ийн нислэгээр 107.6 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 98.7 мянга, “Корейн айр”-ийн нислэгээр 90.3 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 57.6 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 29.2 мянга, Жэжү айр нислэгээр 51.3 мянга, Туркиш айр нислэгээр 46.7 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 37.8 мянга, Т-вей нислэгээр 35.4 мянга, АероК нислэгээр 17.2 мянга, Ираеро нислэгээр 9.7 мянган зорчигч, Юнайтед эйрлайнс нислэгээр 9.7 мянга, бусад авиа компаниудаар 35.5 мянган зорчигч тус тус олон улсад зорчсон байна. /Зураг 25/

Зураг 25. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь




4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % /өссөн дүн/
		7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
1	Орон нутагт зорчигч тээвэр	40,205	243,329	43,441	250,746	3.0%
2	чиглэл Оюутолгой	26,814	200,684	29,706	206,873	3.1%
3	Ховд	1,673	8,555	1,768	10,219	19.5%
4	Өлгий	1,742	6,442	2,949	10,089	56.6%
5	Алтай	1,169	5,352	946	4,468	-16.5%
6	Мөрөн	4,569	7,828	4,079	8,589	9.7%
7	Улиастай	842	3,848	874	3,981	3.5%
8	Улаангом	1,075	3,354	1,611	4,888	45.7%
9	Бусад	0	240	0	131	-45.4%

Зураг 26. Орон нутгийн зорчигч, чиглэлээр




■ 2025 оны эхний 7 сар ■ 2024 оны эхний 7 сар

2025 оны 7 дугаар сард орон нутагт нийт 43.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 8%-аар өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр орон нутагт нийт 250.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 3%-аар өссөн байна. Улаангом, Өлгий, Ховд чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн хэвээр байна. /Хүснэгт 9/

Зураг 27. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2025 оны өссөн дүнгээр агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 60.6% буюу 151.9 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 24.3% буюу 60.9 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 15.1% буюу 37.8 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр, захиалгат нислэгээр 130 зорчигч тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-ийн зорчигч 4.8%-аар буурсан бол “Аэро Монголиа” ХХК зорчигч 29.6%-аар, “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 2.7%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 27/

4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	2024 он		2025 он		Хүснэгт 10 Өсөлт, бууралтын %/өссөн дүн/
	7 дугаар сар	Өссөн дүн	7 дугаар сар	Өссөн дүн	
Нийт нислэгийн тоо	8,988	49,898	10,808	59,742	19.7%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	6,052	36,740	7,036	44,645	21.5%
Хөөрөлт, буулт	2,936	13,158	3,772	15,097	14.7%
Олон улсын хөөрөлт, буулт	1,563	7,187	1,841	8,153	13.4%
Орон нутгийн хөөрөлт, буулт	1,373	5,971	1,931	6,944	16.3%

2025 оны 7 дугаар сард нийт нислэгийн тоо 10,808 болж өмнөх оны 7 дугаар сартай харьцуулахад 20.2%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 7,036 болж 16.3%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 1,841 болж 17.8%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 1,931 болж 40.6%-аар тус тус өссөн байна.

2025 оны эхний 7 сард нийт нислэгийн тоо 59,742 болж өмнөх оны мөн үеэс 19.7%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 44,645 болж өмнөх оны мөн үеэс 21.5%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 8,153 болж өмнөх оны мөн үеэс 13.4%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 6,944 болж 16.3%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 28/

Зураг 28. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

